

9

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Б. Сайнжаргал, Т. Жааваа

Монголд энгийн тоо бүртгэлээс ангид мэдээллийн баялаг уламжлал, анхан шатны баримтад суурилсан бүртгэл тайлагналын болон хэмжүүрийн систем байгаагүй. Нягтлан бодох бүртгэл, тайлагналын системийн үүсэл хөгжил нь улс гүрний эрхэлж буй аж ахуй, үйлчилж буй татварын системтэй холбоотойгоор аж ахуйг үр өгөөжтэй хөтлөх, хянах мэдээллийн практик хэрэгцээгээр тодорхойлогдож ирсэн, цаашдаа ч тийм байх болно.

Монгол орны уламжлалт аж ахуйн систем нь амиа аргацаасан нүүдлийн мал аж ахуй бөгөөд малын тоо, өрх гэр, ам бүлд ногдуулдаг татварын систем хэрэглэгдэж ирсэн учраас аж ахуйн нэгжийн хоёр талт дансны бүртгэл, санхүүгийн тайлангийн хэрэгцээ тэр бүр байгаагаагүй, энэ байдалдаа тохирсон энгийн бүртгэл уламжилж иржээ. Түүнээс бус аж ахуй эрхлэх "хоцрогдол" нь нягтлан бодох бүртгэл хөгжөөгүйн шалтгаан биш болов уу. **1920-оод** онд үндэсний мөнгөн тэмдэгт, хэмжүүрийн нэгдмэл систем, **30-аад** онд давхар бичилтийн нягтлан бодох бүртгэл, **40-өөд** оноос зардлын нэгдсэн төсөв бүртгэл нэвтэрсэн.

1960 онд журнал маягт хэрэглэж, **70-аад** оноос бүртгэл мэдээллийг механикжуулах эхлэл тавьж, **80-аад** онд хэмнэлт, чекийн данс, норматив бүртгэл зэрэг шуурхай хяналт нэвтрүүлэхийг оролдсон ч олигтой үр дүнд хүрээгүй, **90-ээд** оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үөийн бүртгэлийн системийг халж, дэлхийн мэдээллийн даяарчлалд нэгдэн, олон улсын жишигт нийцсэн стандарт бүртгэлийг нэвтрүүлэх алхамууд эхэлжээ.

Ялангуяа улс орны эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлснээр үндэсний нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоо, мэдээлэл боловсруулалтын технологийг эдийн засгийн шинэтгэл хийгээд мэдээллийн даяарчлалд нийцүүлэн үндсээр нь эргэн хянаж, дэлхийн жишиг, хөгжлийн сонгомол хэлбэрт ойртуулах нь чухал болов.

Зах зээлийн харилцаанд нийцүүлэн үндэсний нягтлан бодох бүртгэл, аудитын шинэ тогтолцоог

төлөвшүүлэхийн тулд юуны өмнө зохих мэргэжлийн удирдлага, хууль зүйн орчинг бүрдүүлж, бүртгэлийн үүрэг, арга технологи, олон улсын жишиг, стандартын талаар үзэл ойлголтыг бүрдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг шинээр бэлтгэх буюу давтан сургаж чанаржуулах зайлшгүй шаардлага гарсан юм.

1993-1997 онд Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэл, Аудитын Хуулиудыг баталж, Монголын нягтлан бодох бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, стратеги боловсруулж, зохих сургалт, судалгаа, туршилт бүхий олон шаттай төслүүд хэрэгжүүлсэн.

Аккруэл суурьт бүртгэлд шилжих тухай Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн хуулийг 1993 онд тунхагласнаас хойш хугацаанд Монгол Улсын Үнэт Цаасны Хороо, Улсын Татварын Ерөнхий Газар, Нягтлан Бодох Бүртгэлийн Мэргэжлийн Зөвлөл, Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, хөндлөнгийн хяналтын итгэмжлэгдсэн албад зэрэг шинэ бүртгэлийн тогтолцоонд нөлөөтэй төрийн ба олон нийтийн, мөн хувийн хэвшлийн мэргэжлийн хяналтын байгууллагууд үүсэв.

Нягтлан бодох бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр, төслийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчнийг чадваржуулахад анхаарч, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн нягтлан бодогч-аудитор бэлтгэх, давтан сургах, шалгаруулах үндэсний тогтолцоог бүрдүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл, аудитын онол практикийн болон ажил мэргэжлийн нарийн шалгуур хангасан нягтлан бодогчдод мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгодог болов. 2002 оны байдлаар Монголд 800 мэргэшсэн нягтлан бодогч байгаа нь нийт нягтлан бодогч, практик ажилтны хоёр орчим хувь гэсэн үг. 1993-2000 онд бүртгэлийн боловсон хүчин, практик ажилтны 30 орчим хувь буюу 10000 хүн мэргэжлийн давтан сургалтад хамрагджээ. Бас нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, мэргэжлийн нижгээд ном, сурах бичиг, гарын авлага, арга зүйн материал, ажил мэргэжлийн нэр томъёоны тайлбар толь зэргийг эх хэл дээр орчуулж хэвлүүлсэн.

Үндэсний бүртгэлийн системийг дэлхийн жишиг, олон улсын стандартад нийцүүлэх ажил манайд 1995 оноос эхлэж, энэ хугацаанд үндэсний бүртгэлийн нилээд хэдэн заавар журам боловсрогдож, бизнесийн орчинд туршиж хэрэглэх үйл явц эхлэж, ашгийн төлөө байгууллагуудын бүртгэлийн шинэчлэл ид явагдаж байна.

Гэвч бүртгэлийн шинэчлэлийн үр дүн өнөөдөр тийм ч сайнгүй байна. Үндэсний нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, практик ажилтны дөнгөж 30 хувь шинэчлэгдсэн бүртгэлийн анхан, дунд шатны сургалтад хамрагдсан, ахисан шатны сургалт төдийлөн хийгдээгүй. Мэргэшсэн нягтлан бодогчдын тоо, чанар хангалтгүй, мэдлэг мэргэжил, ур чадвар олон улс, түүний дотор Ази Номхон Далайн бүс нутгийн төвшинд өрсөлдөхүйц хэмжээнд хүрч чадаагүй байна.

Бүртгэлийн системийн шинэчлэл зөвхөн аж ахуй, бизнесийн хүрээнд явагдаж, үйлдвэрлэлийн бус хүрээ, төр захиргаа төсвийн байгууллага хамрагдаж чадаагүй байна. 2001 онд СЭЗЯ, ҮТЕГ-ын хийсэн бүртгэл хөтөлөлтийн улсын үзлэгээр анхан шатны бүртгэл нэвтрэлт улсын хэмжээгээр 70,9 хувь, нягтлан бодох бүртгэл хөтөлөлт 70,3 хувьтай байгаа ба нийт аж ахуйн нэгжийн 61 хувь буюу 17686 байгууллага үзлэгт хамрагдсанаас 66,5 хувь нь санхүү ба татварын тайлан тогтмол гаргаж, 21,8 хувь нь зөвхөн татварын тайлан үйлдэж, 16,8 хувь буюу 2968 нэгж санхүү ба татварын тайлан огт гаргадаггүй байв. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрэлт үзлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн 27,1 хувьд бүрэн, 32,1 хувьд хагас дутуу, 40,8 хувьд огт нэвтрээгүй гэсэн дүн гарчээ.

Ихэнх бизнес нэгж, байгууллагууд дансны жагсаалт, ангилал кодын шинэчлэл, гадаад санхүүгийн тайлан хөрвүүлэлтээр бүртгэлийн шинэчлэлийг хязгаарлаж, анхан шатны баримт, ажил гүйлгээ, мөнгөн урсгалын үнэлгээ, орлогыг хүлээн зөвшөөрөх шалгуурыг оролцуулан санхүүгийн мэдээлэл боловсруулалтыг төгөлдөржүүлэхэд чиглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого горимуудыг тэр бүр тогтсон жишгийн дагуу зөв томъёолж хэвшүүлээгүй байлаа.

Бизнес орчны бүртгэлийн систем, гадаад санхүүгийн тайлагналд чанарын мэдэгдэхүйц ахиц дэвшил гарч, дэлхийн жишигт ойртож буй хэдий ч өртөг, зардлын бүртгэл хяналт, дотоод мэдээллийн сүлжээ, удирдлагын бүртгэлийн технологи манайд хараахан төлөвшиж чадаагүй байна. Энэ асуудлыг онол практикийн үүднээс нэгтгэн судлаж, микро төвшний удирдлага, хяналтыг бэхжүүлэх, нэн ялангуяа бизнес орчны өртгийн бүртгэл, дотоод хяналт, мэдээллийн сүлжээ, удирдлагын хяналтын загварыг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж, бүтээлч эрэл, дорвитой судалгаа одоо хир үгүйлэгдсээр байна.

Монгол бүртгэлийн чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр, төслийн хүрээнд төр, захиргаа, төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийн зарчмыг шинэчилж, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог дэлхийн жишиг, олон улсын бүртгэлийн стандартад нийцүүлэн түргэн өөрчилж цэгцлэх, үүний тулд шинэчилсэн бүртгэлийн зохион байгуулалт, арга зүйн удирдлагыг зөв чиглүүлж, мэргэжлийн хяналтыг бэхжүүлэхийн хамт олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

Бүртгэлийн шинэчлэлийн эхний шатны үндсэн зорилт нь ОУБС-ыг хүлээн зөвшөөрч, түгээмэл жишигт шилжих үзэл бодлыг төлөвшүүлэх явдал байв. Энэ зорилт өнөөдрийг хүртэлх олон арван цуврал арга хэмжээ, хөтөлбөрүүдийн үр дүнд амжилттай хэрэгжсэн гэж дүгнэж болохоор байна. Нягтлан бодох бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, цуврал төслүүдийг хэрэгжүүлэхэд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Австралийн Засгийн Газар, бусад хандивлагчдын санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж чухал үүрэг гүйцэтгэж ирлээ.

Шинэ зууны ойрын 5-10 жилд хэрэгжүүлэх **дараагийн шатны үндсэн зорилт нь бизнесийн түгээмэл хэл болсон бүртгэл-тайлагнал, хяналтын олон улсын жишигт нийцсэн үндэсний системийг бизнесийн төдийгүй, төсвийн болон төр, олон нийтийн байгууллагын хүрээнд бүрэн утгаар нь нэвтрүүлэх явдал юм.**

Шилжилтийн эдийн засгийн энэ зурвас үед үндэсний бүртгэлийн системийг хөгжүүлэх талаар төр засгаас баримтлах бодлогын үндсэн чиглэлүүд нь бидний төсөөлж байгаагаар: **нэгд**, Улс төр, эдийн засаг, хууль зүйн зохих таатай орчинг бүрдүүлэх, **хоёрт**, "Судалгаа-боловсруулалт-хэрэгжүүлэлт-явцын хяналт" мөчлөгийн хүрээнд мэргэжлийн удирдлага, хяналт, зохицуулалтын байгууллагын үр нөлөөг дээшлүүлэх, **гуравт**, Үндэсний бүртгэлийн загвар, стандарт бэлтгэж, мэдээлэл боловсруулалт ба технологид үндсэн эргэлт хийх, **дөрөвт**, Мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг эрчимжүүлэх зэрэг асуудлууд хамаатай.

Үндэсний бүртгэлийн системийг хөгжүүлэхэд юуны өмнө улс төр, эдийн засаг, хууль зүйн зохих таатай орчинг бүрдүүлэх асуудал орно. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол улсын хуулиуд нь эдийн засгийн суурийн шинэчлэл, санхүүгийн тайлагналын орчинг өөрчилж, хувьсал дэвшлийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэж байгааг үгүйсгэх аргагүй.

Тэрчлэн нягтлан бодох бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар бүртгэлийн нэгдсэн бодлого боловсруулах, түүний хэрэгжилт, явцын хяналтыг сайжруулах эрх зүйн орчинг баталгаажуулж байна. Бас төр, захиргаа, төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүжилт,

тайлагналын зарчмыг бүхэлд нь шинэчлэхэд төсөвт байгууллагын удирдлага, санхүүжилт, төрийн хяналтын хуулиудыг баталсан нь нэн чухал алхамууд боллоо.

Судалгаа хөгжүүлэлт, мэргэжлийн хяналт. Өнөөдөр манайд ажил мэргэжлийн судалгаа боловсруулалт, хэрэгжүүлэлт, хяналтын байгууллагын тогтолцоо төгс сайн бүрдээгүйг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бүртгэлийн системийн шинэчлэл, олон улсын стандартын нэвтрэлт сул байгаа нь ч үүнтэй холбоотой. YTEГ, YЦX, HББМЗ, MMHБИ, Xараат бус хөндлөнгийн хяналт зэрэг төр, олон нийт, хувийн хэвшлийн олон байгууллага бий ч шинэчилсэн бүртгэлийн системийн загвар, үндэсний стандарт бэлтгэх нэгдсэн концепц бүрэн тогтоогүй, зөвхөн СЭЗЯ-ны HББМ Хэлтэсээс бүртгэлийн холбогдолтой заавар журмыг бэлтгэж, сайдын тушаалаар батлан хэрэглэгчид шилжүүлдэг журам мөрдөгдсөөр ирлээ.

Төрийн ба төрийн бус статустай олон нийтийн болон хувийн хэвшлийн төрөлжсөн байгууллагууд бүртгэлийн үндэсний системийн загвар, стандарт бэлтгэхэд чухал үүрэгтэйг харгалзан шилжилтийн эхний үед манайд төрийн статустай ийм байгууллагыг үүсгэх нь зүйтэй. Үүнтэй уялдаж СЭЗЯ-ны HББМ хэлтсийг өргөтгөн, санхүүгийн тайланг бэлтгэгч, мэдээлэл хэрэглэгчдийн өргөн нийтийн төлөөллийг багтаасан Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Хороог төрийн статустай байгуулахаар боллоо. Цаашдаа энэ байгууллагыг бие даалган олон нийтийн сектор, эсвэл хувийн хэвшилд аажмаар шилжүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

Дэлхийн жишиг, зах зээл хөгжсөн орны практик туршлагаас үзэхэд нягтлан бодох бүртгэлийн судалгаа боловсруулалт, хэрэгжүүлэлт ба зохицуулалтад ихээхэн анхаарч, мэргэшсэн нягтлан бодогчдын ур чадвар, мэргэжлийн хяналт, зохицуулалтын байгууллагуудын төгс тогтолцоог хөгжүүлэхийг ихэд чухалчилсны үр дүнд Европ, Англи-Сагсон, ОУБС гэгдэх бүртгэлийн томоохон систем загварууд үүсэхэд хүрсэн. Өнөөдөр эдгээр загварууд тодорхой бүс нутаг, улс гүрний хэмжээнд түгээмэл хэрэглэгдэж байна.

Европ загвар (XV-XX зуун). Их эртний уламжлалтай, чөлөөт үйлдвэрлэгч бүхий хувийн хэвшлийн тусгал болж үүссэн. Системийн энэ загвар Англи, Швед, Нидерланд болон Европын холбооны хүрээнд дэлгэрч, сүүлийн үес нэмүү орлого, бүтээгдэхүүн хэмжилд их учир холбогдол өгч, эдийн засгийн макро төвшний загвар ба нийгэм корпорацийн чиг хандлагатай илүү уялдах болсон. Англи-Уэльсийн МНБИ 1975 онд хэвлэж тараасан “Корпорацийн тайлан” системийн загвар дэхь нэмүү орлого хуваарилалт /хөлсний ажилчид, зээлдүүлэгч, хувь нийлүүлэгчдийн дунд/ үүний тод жишээ юм.

Америк (Англи-сагсон) загвар (1933-1975 он). Америкийн мэргэжлийн судалгаа хөгжүүлэлт, зохицуулалтын суурь бүр 1887 онд /1957 онд АМНБИ (AICPA) гэж өөрчилсөн/ тавигдаж, 1934 онд YЦК (SEC), 1936 онд Арга Горимын Хороо (CAP), 1959 онд Зарчмын Хороо (APB), 1972 онд СБСГ (EASB) зэрэг байгууллага үүсч, улмаар системийн загвар бэлтгэх чиг үүрэг 1938 оноос хувийн хэвшилд /CAP, (1933-1959), APB, (1959-1972), EASB, (1972 оноос хойш)/ шилжсэнээр үнэт цаасны арилжаа, капиталын зах зээлийн тусгал болж, Америк бүртгэлийн систем буюу Англи-сагсон загвар /1933-1975 он/ томъёологдсон.

“ОУБС” системийн загвар (1975-2001). Санхүүгийн бүртгэлийн орчны өөрчлөлт, мэдээлэл хэрэглэгчийн байнга өсөн нэмэгдэж буй эрэлт нь нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг олон улсын хэмжээнд зайлшгүй уялдуулж зохицуулахыг шаардаж, улмаар Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (1972 он), Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (1973 он), Үнэт Цаасны Комиссын Олон Улсын Байгууллага (IOSCO), НҮБ-ийн Бүртгэл Тайлангийн Олон Улсын Стандартын Экспертүүдийн бүлэг, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Бүртгэл Стандартын ажлын хэсгийн хамтын чармайлтаар 2 тунхаглал, 34 стандарт, 25 тайлбар бүхий олон улсын бүртгэлийн систем загвар бэлтгэж, санал болгосон

нь улс гүрнүүдийн бүртгэлийн бодлого, аргазүйн болон санхүүгийн мэдээллийн уялдуулсан нэгдмэл байдлыг хангахад нэн чухал үүрэг гүйцэтгэх болов.

Нягтлан бодох бүртгэлийн үндэсний системийн загвар, стандарт. Өнөөдрийг хүртэл манайд нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг тэр хэвээр нэвтрүүлэхээр оролдож ирсэн. Гэвч хөгжлийн ялгаа, төр засгаас явуулж буй бодлогын чиглэл, үндэсний хэв шинж ба онцлог, банк зээлийн харилцааны уламжлал зэрэг олон учир шалтгаануудын улмаас практикт тэр бүр таарч тохирохгүй, зөрчил бэрхшээл тохиолдсоор байгаа ба дэлхийн олон улс гүрний практик туршлагаас үзвэл тэд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишигт нийцсэн үндэсний болон бүс нутгийн стандартыг боловсруулж мөрддөг юм байна. Үндэсний стандартын талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэд, практик ажилтнуудын үзэл ойлголт нэг мөр болж чадаагүй маргаантай зүйл ч нилээд байна.

Олон улсын бүртгэлийн стандартад манайд хараахан байхгүй харилцааг зохицуулсан зүйл тусгагдсан байх явдал элбэг байдаг. Жишээ нь манайд капитал түрээсийн харилцаа, үнэт цаасны гүйлгээ, капиталын зах зээл сайн хөгжөөгүй, давуу эрхийн хувьцаа, хөрвөгч үнэт цаас, опцион, хувьцааны эрх зэрэг онцгой төрлийн үнэт цаас одоо хир гараагүй, өмчийн нийлмэл бүтэц үүсээгүй байна. Иймээс Монгол улсад Олон Улсын Стандарт, дэлхийн жишигт нийцсэн нягтлан бодох бүртгэл, аудитын үндэсний стандарт, өвөрмөц системийн загвар шаардлагатай байгаа бөгөөд түүнийг бэлтгэхдээ өөрийн орны дараах онцлогуудыг харгалзах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын цар хүрээ, хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, хэмжээ
- Бүртгэлийн мэргэшсэн ажилтнуудын мэргэжлийн бэлтгэл, туршлага, ур чадвар
- Мэдээлэл боловсруулалтын арга (гар, компьютерт суурилсан гар ажиллагаатай, компьютерээр гэх мэт)
- Мэдээлэл хэрэглэгчдийн хүрээ, хэрэгцээ шаардлага, тэдгээрийн ашиг сонирхол зэрэг байж болох юм.

Бидний одоогийн (урьдчилан) төсөөлж байгаагаар бүртгэлийн үндэсний стандарт нь бүрдэл хэсгийн хувьд:

- Нягтлан Бодох Бүртгэл-Аудитын олон улсын стандартын нэмэлт тайлбар тодруулга
- Үндсэн болон байж болох хувилбаруудын зөв сонголт
- Нийтлэг мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дүрэм журам, заавар аргачиллыг багтаасан байх юм.

Нягтлан бодох бүртгэлийн системийг шинэчлэх нь нэг хэрэг, харин түүний үр дүнг хэрэглэж сурах, өөрөөр хэлбэл мэдээллийн баазыг зөв бүрдүүлж, судалгаа боловсруулалтыг хөгжүүлэн, санхүүгийн гүйцэтгэлийг хянах үзүүлэлтүүдийн систем, түүний жишиг хэмжээг тогтоож, шинжилгээний зохион байгуулалт, арга зүйг хөгжүүлэх нь удирдлагын үр өгөөжийг дээшлүүлэхэд нэн чухал болно.

Бүртгэлийн системийн загвар нь зөвхөн санхүүгийн бүртгэл, гадаад тайлагнал төдийгүй, татварын болон зардал удирдлагын бүртгэл, дотоод тайлагнал мэдээллийн дотоод сүлжээ-хяналт, санхүүгийн төсөвлөлт-гүйцэтгэлийн шинжилгээ дүгнэлт, аудитыг хамарсан иж бүрдэл байх ёстой.

Бид энэ зорилгоор “Монгол улсын бизнесийн болон ашгийн бус байгууллагын бүртгэл-аудитын тогтолцоо” сэдэвт төслийн хүрээнд судалгаа хийж, мэргэжлийн эрдэмтэн, судлаач-багш, бүртгэлийн мэргэжилтэн, практик ажилтан оролцсон үндэсний нягтлан бодох бүртгэлийн системийн загвар, стандарт бэлтгэх ажлын хэсгүүд ажиллаж, “Санхүүгийн тайланг бэлтгэх, мэдээлэх үзэл баримтлалын зарчим”, “Санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэлт” гэж нягтлан бодох

бүртгэлийн үндэсний стандартын тунхаглалын 2 үндсэн баримт бичгийн төсөл, санхүүгийн тайлан, өмч, үүрэг хариуцлага, орлого, үр дүнгийн хэмжил, тайлагналд хамаарах салбар стандартын тайлбарууд бэлтгэж, хэлэлцүүлгийг эхлээд байна.

Үндэсний стандартын төслийг хамтын хүчээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгч, сонирхогч олон нийт, мэргэжлийн байгууллага ба бусад талуудын хүч чармайлтаар хууль зүйн хүрээнд зөвшиж хэвшүүлэх нь монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хөгжлийн чухал алхам болно.

Бүртгэлийн шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсон хүчин шийдвэрлэх үүрэгтэй. Өнөөдөр төрийн болон хувийн өмчийн 20 гаруй сургуульд бүртгэлийн мэргэжлээр 5000 гаруй оюутан суралцаж жилд дунджаар 1000 орчим хүн бакалаврын зэрэглэлээр төгсөж, магистр, докторын сургалт эхлэлийн шинжтэй байгаа боловч бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийн дүнгээс үзвэл 14000 шахам нягтлан бодогчид хамрагдсаны 63,6 хувь дээд, 29,3 хувь тусгай дунд, 7,1 хувь нь бүртгэлийн мэргэжил эзэмшээгүй хүмүүс байжээ.

Бүртгэл-санхүүгийн ажилтнуудын эрхэлсэн ажлын болон санхүүгийн менежмент, Бүртгэлийн программ хангамж түүнийг хэрэглэх мэдлэг чадвар сул байгаа нь бүртгэлийн шинэчлэлд сөргөөр нөлөөлж байгааг нуух аргагүй. Энэ байдалд дүгнэлт хийж бүртгэлийн ажилтныг давтан сургах, дахин шалгаруулалт хийх, ажил мэргэжлийн болон ажлын байрны тодорхойлолтыг гаргах, Үндэсний эксперт-зөвлөхийн хэмжээнд ажиллах хүмүүсийг гадаадын их дээд сургуулийн магистрантурт зориуд бэлтгэх болон мэргэжлийн сургуулиудын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийж, сургалтын чанар, багшлах бүрэлдэхүүн, суралцах орчин, хангамжыг сайжруулах шаардлагатай байна.